

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРААС “ХҮҮХЭД,  
ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН  
АЖЛЫН МЭДЭЭ**

2018-06-04

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хугацаа	Хамтран зохион байгуулагч
1	“Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарах асуудал” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, кэйс дээр ажиллах аргачлал арга зүйгээр хангаж, хамтарсан багийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарах асуудал” сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт Дархан сумын ГХУСАЗСЗ-ийн дарга Ж.Балжинням, ЭМГ-ын дарга Батцэнгэл, БСУГ-ын дарга Р.Батжаргал нар оролцож, Дархан сумын багийн засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмнэлгийн ахлах эмч, ЕБС-ийн нийгмийн ажилтан, ХХҮГ-ын мэргэжилтэн нийт 110 хүн хамрагдлаа. Оролцогчдод Холбон зуучлах үйлчилгээний журам, Нөхцөл байдлын үнэлгээний журам, Хамтарсан багийн санхүүжилтийн журам, Хууль зүйн хорооны журмыг гарын авлагаар түгээж, бүлгийн ажил кэйс менежмент, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зураглал боловсруулалт зэрэг арга зүйн хүрээнд зохион байгууллаа. Зардал 604,200 төг.	1Ү/16	ГБХЗХГ Дархан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
2	Хүүхдийн тусламжийн 108 утасны хариу үйлчилгээ үзүүлэх	Хүүхдийн тусламжийн утас 108-аас нийт 67 дуудлага мэдээлэл хүлээн авснаас 65 дуудлага буюу 97% шийдэгдсэн, 2 дуудлага буюу 3% хяналтад шийдвэрлэх шатанд явж байна. Аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн дуудлага мэдээлэл 26, үүнээс хариу үйлчилгээ үзүүлсэн тухай эргэн мэдээлэл авсан 20, хэрэг үүсээд шалгагдсан 6. Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын дуудлага мэдээлэл 55, сургуулийн орчинд дахь хүүхэд хамгааллын дуудлага мэдээлэл 7, бусад гомдол мэдээллийн дуудлага 5. Өмнөх онд 32 дуудлага ирсэн бол 2018 онд 67 дуудлага ирсэн нь 2,1 дахин өссөн үзүүлэлттэй байна.	2018 оны 5 сарын байдлаар	ГБХЗХГ Хамтарсан баг
3	Дархан сумын хамтарсан багт бичиг хэргийн зардал олгох	Аймгийн хэмжээний нийт 26 Хамтарсан баг бүрд бодит дэмжлэг болгон ажлын хэрэгцээнд хавтас, бичгийн цаас, гарын авлага ном, хамтарсан багийн үйлчилгээний бүртгэлийн дэвтрийг хэвлүүлэн өгч, анхан шатанд хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай өгч ажиллаж байна. Зардал 585,000 төг.	1Ү сард	ГБХЗХГ
4	Сурталчилгааны материал бэлтгэх	ХЭТХ, ХХТХ, ГБХТТХуулийн брошур, Хүүхдэдээ бахархан дуурайх аав, ээж нь байя гарын авлага нийт 2000 ш хэвлүүлэн	1Ү-Ү сард	ГБХЗХГ

		олон нийтэд түгээв. Зардал 700,000 төг.		
5	Хүүхэд хамгааллын эрх зүйн орчны хүрээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Орхон, Хонгор, Шарын гол суманд ажиллаж, хамтарсан багт Цагдаагийн газартай хамтран сургалт зохион байгуулж, бичиг хэргийн материал, холбогдох хууль тогтоомж, гарын авлага материалаар хангаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	1Y-Y сард	ГБХЗХГ ЦГ
6	“Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” аян	Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” аяны нээлтийн үйл ажиллагааг “Хүчирхийлэлгүй өнөөдөр-Хүчирхийлэлгүй ирээдүй” уриан дор ЕБС-ийн 550 гаруй хүүхэд нэгдэж Флаш моб бүжиглэн, аймгийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн албатай хамтран “Нээлттэй төр” онлайн шууд нэвтрүүлэгт оролцож аяны нээлтийн талаарх мэдээллийг түгээж олон нийтэд уриалан түгээв. “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” үндэсний аяны хүрээнд ОИЦ, 4-р сургууль, Цагдаагийн газар, Хонгор, Орхон сумын багш, эцэг эхчүүдэд нийт 6 удаа 587 хүнд сургалт зохион байгуулж, “Хүүхэд амьдралаас бүхнийг суралцдаг” сургагч багш бэлтгэх 8 цагийн сургалтад ЕБС-ийн 22 эцэг эхийн зөвлөлийн төлөөллийг сургагч багшаар бэлтгэлээ. “Хүүхдэдээ бахархан дуурайх аав, ээж нь байя” брошур 1500 ш хэвлүүлж, 600 гаруй брошур гарын авлагыг түгээлээ. Орон нутгийн DBS тв-ээр “Хүүхдийг хэрхэн эерэг аргаар хүмүүжүүлэх вэ?” нэвтрүүлэгт оролцов. Зардал 261,800 төг.	1Y/30 Y/03 Y1/01	ГБХЗХГ Хууль, эрх зүйн хэлтэс Орхон сумын 8-р сургууль ЦГ ЕБС-ийн эцэг эхийн зөвлөл DBS телевиз
7	ОУ-ын гэр бүлийн өдрийг зохион байгуулах	Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан 9 үйл ажиллагаа төлөвлөн, “Гэр бүлийн хоёрдугаар зөвлөгөөн”, “Хөгжилтэй өдөр” гэр бүлийн хөгжөөнт спортын тэмцээн, Ахмадаас суралцья, “Миний ертөнц” гар зураг, эссэ бичгийн уралдаан, 50 залуу гэр бүлд “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” сургалт зохион байгуулж, Угийн бичиг хөтлөх арга зүйн анхдугаар зөвлөгөөнд 600 гаруй иргэн хамруулан зохион байгууллаа. Зардал 625,900 төг.	Y/15-20	ГБХЗХГ Сумдын ЗДТГ Ахмадын хороо БТСГазар Хүүхдийн элч Гэр бүлийг алдаршуулах төв
Аяны хүрээнд нийт 1294 насанд хүрэгч, 717 хүүхэд, 2011 хүнийг оролцуулан, 18 байгууллагатай хамтран ажилласан. Зардал ГБХЗХГ-аас 2,776,900 төг.				

ХЯНАСАН: ДАРГА

А.АМГАЛАН

ТАЙЛАН МЭДЭЭ БИЧСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЁЛМАА



### ОУ-ын гэр бүлийн өдөр



“Хүүхдийг зэрэг аргаар хүмүүжүүлье” аян



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

**“ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ  
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

 pdfelement